



ШУДАРГА БАЙДЛЫН БОДЛОГО

ЮРИКА ХХК-ийн Байгаль орчны газар нь магадлагаа нотолгооны үйл ажиллагаа явуулахдаа холбогдох эрх зүйн шаардлагын дагуу, хараат бус, ил тод, шударга байдлыг дээдлэж, мэдээллийн нууцлалыг хамгаалан, олон улсын стандартыг дагаж мөрдөж ажиллах бөгөөд аливаа хууль бус явдалтай эвлэршгүй байж, нээлттэй, нэг талыг баримтлахгүй, гадаад болон дотоод бүхий л сонирхогч талуудыг үл ялгаварлан харилцан тэгш, тэнцвэртэй байдлыг хангаж арилжаа, санхүүгийн болон бусад аливаа ашиг сонирхлын нөлөөнд автахгүйгээр магадлагаа нотолгооны байгууллагын нэр төрийг ухамсартайгаар хамгаалж ажиллана.

Байгаль орчны газар нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй аливаа үйл ажиллагаанд татагдаж орохгүй бөгөөд хэрэв магадлагаа нотолгооны үйл ажиллагаа хийх явцад дараах эрсдэлтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд ажилтан Байгаль орчны газрын удирдлагад нэн даруй мэдээлэх үүрэгтэй:

- Ашиг сонирхлын зөрчил;
- Бие даасан байдалд нөлөөлөх;
- Шударга байдал алдагдах.

Бид төсөл болон байгууламжийн хүлэмжийн хийн мэдэгдэлд ISO 17029:2022, ISO/IEC 14065:2020 стандартын дагуу Хүлэмжийн хийн хөтөлбөр шаардлага болон аргазүйд тулгуурлан магадлагаа нотолгоо гаргана.

ЮРИКА ХХК-ийн Байгаль орчны газрын үнийн бодлогод дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

1. Төсөл/байгууллагын төрөл;
2. Ажилчдын тоо;
3. Төслийн хэмжээ – хүлэмжийн хийн тооллогод хамрагдсан жижиг/том хэмжээний буюу хамрах хүрээ (1,2,3);
4. Магадлагаа нотолгоо хийх төсөл/байгууллагын газарзүйн байршил;
5. Үнэлгээчдийн арга хэрэгсэл, аргачлалын түвшин.

Магадлагаа, нотолгооны үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаарддагдах хугацаа нь дараах хүчин зүйлээс хамаарна.

1. Ажиллаж буй хүний нөөцийн тоо
2. Магадлагаа нотолгооны нарийн төвөгтэй байдал
3. Магадлагаа, нотолгоо гаргахад шаардлагатай мэдээлэл/баримт бичиг/нотлох баримт байгаа эсэх;

Тухайн магадлагаа нотолгооны үйл ажиллагаа авч буй байгууллагын хамтран ажилласан зөвлөх байгууллага эсвэл санхүүгийн байгууллага зэрэг хүчин зүйлүүд нь манай талаас магадлагаа нотолгоо хийх цаг хугацаа, үнэ, арга аргачлалд аливаа төвөгтэй байдал ямар нэгэн аливаа нэгэн нөлөөлөл байхгүй.

2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр